



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 07 сарын 15 өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2003-2004 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НБ:

1. Ёндон овогтой Гантулгыг Австрали улсын Гриффит Их сургуулийн магистрантурт холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Баатар овогтой Цэвэлмааг Швед улсын УМЕА Их сургуулийн магистрантурт нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Батсайхан овогтой Ариунааг ХБНГУ-ын Хайделбергийн Их сургуулийн докторантурт орчны химийн чиглэлээр 3 жилийн хугацаагаар 2003-2004 оны хичээлийн жилээс тус тус суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

[Handwritten signature]
А.ЦАНЖИД